

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2020 оны сарын-ны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт

**ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН,
ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.16 дахь заалтыг үндэслэн геологи, уул уурхайн салбарын инженерүүдэд мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллагыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ажлын хэсэг байгуулан сонгон шалгаруулна.
- 1.3. Мэргэшлийн зэрэг горилогч нь мэргэшсэн мэргэжилтний эрхийг авснаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс шинжээчээр томилогдон ажиллах боломжтой болно.

Хоёр. Мэргэжлийн төрийн бус байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 2.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх) нь мэргэшсэн мэргэжилтний эрх олгох үйл ажиллагааг геологийн ба уул уурхайн чиглэлээр гүйцэтгүүлэх бөгөөд чиглэл тус бүрт шалгарсан мэргэжлийн төрийн бус байгууллагатай (цаашид “төрийн бус байгууллага” гэх) хамтран ажиллах гэрээг байгуулна.
- 2.2. Төрийн бус байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
 - 2.2.1. геологи, уул уурхайн салбарын инженерүүдэд мэргэшсэн мэргэжилтний эрх олгох асуудлыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах;
 - 2.2.2. геологийн бүх төрлийн судалгаа, ашигт малтмал ашиглах чиглэлээр зөвлөмж, дүгнэлт гаргах мэргэшсэн мэргэжилтний эрх олгох;
 - 2.2.3. геологи, уул уурхайн салбарын инженерүүдэд мэргэшсэн мэргэжилтний эрх олгох хүрээнд зэргийн сургалт, давтан сургалтыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх;

- 2.2.4. үйл ажиллагааныхаа чиглэлээр гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах;
- 2.2.5. олон улсад геологи хайгуул, уул уурхайн чиглэлээр баримталж байгаа заавар, журам, стандартыг өөрийн орны онцлогт нийцүүлэн нэвтрүүлэх, нутагшуулах, хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллах;
- 2.2.6. геологи, уул уурхайн салбарт үндэсний мэргэжилтнүүдийн үнэлэмжийг өсгөх, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;
- 2.2.7. геологи, уул уурхайн салбарын инженерүүдийн залгамж халааг бэлтгэх, чадваржуулах;
- 2.2.8. мэргэшсэн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн дүрмийг батлах, ёс зүй ба гомдол хэлэлцэх хороог байгуулах;
- 2.2.9. геологи, уул уурхайн салбарын мэргэжлийн чиглэл тус бүрээр мэргэшсэн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөр боловсруулах, шалгалт авах, мэргэшсэн мэргэжилтний эрх олгох талаар санал өгөх мэргэшсэн мэргэжилтний хороог төрийн байгууллага, мэргэжлийн холбоо, их, дээд сургууль, сургалтын төвийн төлөөллийг оролцуулан байгуулах;
- 2.2.10. төрийн бус байгууллагын гүйцэтгэх удирдлага нь энэ журмын 2.2.9-д заасан хорооны саналыг үндэслэн мэргэшсэн мэргэжилтний эрхийг олгох, сунгах, хүчингүй болгох тухай шийдвэр гаргах;
- 2.2.11. энэ журмын 2.2.10-д заасан шийдвэрийг төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр танилцуулан хянуулж, мэргэшсэн мэргэжилтний эрхийг олгох, сунгах, хүчингүй болгох асуудлыг төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталгаажуулах;
- 2.2.12. мэргэшсэн мэргэжилтний эрхийг хүчингүй болгох асуудлыг тухайн этгээдэд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр шийдвэрлэх;
- 2.2.13. мэргэшсэн мэргэжилтний мэдээллийн санг бүрдүүлж ажиллах. Үүнд:
 - Сургалтад хамрагдсан хөтөлбөр, хугацаа, огноо;
 - Шалгалтын дүн, огноо;
 - Хамгаалсан сэдэв, хийсэн бүтээл;
 - Гэрчилгээний мэдээлэл (гэрчилгээ олгосон тушаалын дугаар, огноо, хамрах хүрээ, хүчинтэй хугацаа, сунгалт);
 - Бусад шаардлагатай мэдээллүүд.

Гурав. Мэргэшсэн мэргэжилтний эрх олгох, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааг болон сургалтыг зохион байгуулах

- 3.1. Мэргэшсэн мэргэжилтэн гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.26 дахь заалтад дурдсан эрх олгогдсон иргэнийг хэлэх бөгөөд

- Монгол Улсын мэргэшсэн, зөвлөх гэсэн шатлал бүхий мэргэшлийн зэрэгтэй байна.
- 3.2. Төрийн бус байгууллага нь геологи, уул уурхайн салбарын мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааг болон сургалтыг зохион байгуулна.
 - 3.3. Энэ журмын 3.2-т заасан үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ.
 - 3.3.1. мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг салбарын мэргэжилтний суралцах хэрэгцээ шаардлага, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх эрэлт хэрэгцээнд үндэслэн боловсруулж төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах бөгөөд агуулгын хувьд онолын мэдлэгээс гадна суралцагсдад дадлагын ур чадвар олгоход чиглэсэн байна;
 - 3.3.2. сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу холбогдох байгууллагатай хамтран танхимын хэлбэрээр явуулах бөгөөд үүнтэй дүйцэхүйц эрдэм шинжилгээний хурал, семинар болон бусад хэлбэрээр зохион байгуулж болно;
 - 3.3.3. энэ журмын 3.4-т заасан шаардлагыг хангасан мэргэшлийн зэрэг горилогчийг сургалтад хамруулна;
 - 3.3.4. сургалтад хамрагдсан мэргэшлийн зэрэг горилогчоос энэ журмын 2.2.9-д заасан хороо шалгалт авч, гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана.
 - 3.4. Мэргэшлийн зэрэг хүссэн горилогч нь дараах үндсэн болзол, шалгуурыг хангасан байна:
 - 3.4.1. геологи, уул уурхайн чиглэлээр их, дээд сургууль төгсөж дээд боловсрол эзэмшсэн байх;
 - 3.4.2. мэргэшсэн зэрэг горилогч нь мэргэжлээрээ 10-аас доошгүй жил, үүнээс мэргэшлийн чиглэлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;
 - 3.4.3. зөвлөх зэрэг горилогч нь мэргэжлээрээ 20-иос доошгүй жил ажилласан, эсхүл мэргэшсэн зэрэг авснаас хойш 6 жил ажилласан байх;
 - 3.4.4. Зөвлөх зэргийг 2 удаа сунгуулснаас хойш хугацаагүй олгоно.
 - 3.5. Энэ журмын 3.3.2-т заасан сургалтад хамрагдсан, 3.4-т заасан болзол шалгуурыг хангасан горилогчид журмын 3.3.4-т заасан шийдвэрийг үндэслэн төрийн бус байгууллагын гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр мэргэшлийн зэрэг олгох бөгөөд мэргэжлийн гэрчилгээ, батламжийг төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталгаажуулж, хувийн тэмдэг олгоно.
 - 3.6. Геологи, уул уурхайн мэргэжлийн чиглэлээр боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн мэргэшлийн зэрэг олгож болно.
 - 3.7. Мэргэшлийн зэрэг сунгах, хүчингүй болгох нөхцөл:

- 3.7.1. мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй мэргэшсэн мэргэжилтнийг хяналтын модуль (цуглуулах оноо) цуглуулсан тохиолдолд 3 жил тутамд зэргийг нь сунгана;
- 3.7.2. мэргэшлийн зэрэгтэй мэргэшсэн мэргэжилтний хяналтын модуль (цуглуулах оноо)-ийг төрийн бус байгууллагаас тогтооно;
- 3.7.3. мэргэшлийн зэргээ сунгуулах хүсэлт (өргөдөл)-ийг энэ хугацаанд хийсэн ажлын болон мэргэжил дээшлүүлсэн талаарх тайлан, тодорхойлолтын хамт төрийн бус байгууллагад бичгээр ирүүлнэ;
- 3.7.4. мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд мэргэшлийн зэрэг хүчингүй болсонд тооцно;
- 3.7.5. төрийн бус байгууллагаас баталсан ёс зүйн дүрэм болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд мэргэшлийн зэргийг төрийн бус байгууллагын ёс зүй ба гомдол хэлэлцэх хороо, мэргэшсэн мэргэжилтний хороо, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн эрх олгосон байгууллагаас хүчингүй болгоно;
- 3.7.6. төрийн бус байгууллага нь мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох хүрээнд гаргасан шийдвэрээ тухай бүр төрийн захиргааны төв байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.

Дөрөв. Мэргэшсэн мэргэжилтний ёс зүйн ерөнхий зарчим

- 4.1. Мэргэшсэн мэргэжилтэн нь төрийн бус байгууллагаас баталсан ёс зүйн дүрмийг баримталж ажиллана.
- 4.2. Мэргэшсэн мэргэжилтэн нь шударга ёс, бодит байдал, мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар, хянамгай байх, хараат бус байдал, мэдээллийн нууцыг хадгалах, техник, арга зүйн стандартуудыг баримтлах, мэргэжлийн нэр хүндийг дээдлэх зэрэг зарчмыг баримтална.
- 4.3. Мэргэшсэн мэргэжилтэн нь төрийн бус байгууллагаас баталсан ёс зүйн дүрмийг зөрчсөн бол мэргэжлийн ёс зүйг зөрчсөн гэж үзнэ.

Тав. Хэрэгжилтэнд тавих хяналт

- 5.1. Төрийн бус байгууллага нь холбогдох нэгдсэн тайлан мэдээллийг жил бүрийн 12 сарын 10-ны өдрийн дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 5.2. Энэхүү журмын дагуу зохион байгуулж байгаа аливаа үйл ажиллагаанд төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.
- 5.3. Төрийн бус байгууллага нь энэхүү журмын дагуу зохион байгуулж байгаа аливаа үйл ажиллагаа, холбогдох тайлан болон мэргэшсэн мэргэжилтний мэдээллийг ил тод нээлттэй байлгана.

- 5.4. Гэрээ байгуулсан төрийн бус байгууллага нь гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн эсхүл цаашид биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд төрийн захиргааны төв байгууллагын санаачлагаар гэрээг цуцалж болно.

Долоо. Журмыг дагаж мөрдөх

- 6.1. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

--oo0oo—